



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 425

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 1338 дугаар шийтгэх тогтоолоор гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон тул Улсын онц чухал объектын үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулах шаардлагаар “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Анхбаярыг 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах.

1.2. Авлигатай тэмцэх газрын 2018 оны 05/8113 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2018 оны а/3423 дугаар албан бичгээр ирүүлсэн саналын дагуу “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар Ү.Төмөрхуягийг томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.


2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



Боловсруулсан
Хянасан
Хуваа